



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/175

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.1.9 дэх заалтыг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын байгууллагын Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн санг ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Онцгой байдлын байгууллагын Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сан”-г үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, ажиллахыг Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга (хурандаа Б.Ууганбаяр)-д даалгасугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ  ГАРИУНБУЯН



00001929

**ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН
“ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАХИМ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН
САН”-Г АШИГЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнуудын эрүүл мэндийн мэдээллийн сан (цаашид “Мэдээллийн” сан гэх) үүсгэх, нууцлал, аюулгүй байдлыг хангах, ашиглахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэдээллийн сан нь бодит үзлэг, шинжилгээ, оношилгоо, биеийн зохистой харьцаа, сэтгэл зүй, дархлаажуулалт гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

1.3. Алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эмчилгээ, сувилгаа хийх, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад оруулах, шаардлагатай тохиолдолд эрэн хайх, аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэхэд томилох зэрэгт мэдээллийн санг ашиглана.

**Хоёр. Мэдээллийн сан бүрдүүлэх,
нууцлал, аюулгүй байдлыг хангах, ашиглах**

2.1. Алба хаагчдын эрүүл мэндийн түүхийн мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн санг бүрдүүлнэ.

2.2. Онцгой байдлын байгууллагын эрүүл мэндийн асуудал хариуцсан алба хаагч нь Онцгой байдлын ерөнхий газраас өгөгдсөн нэвтрэх эрх бүхий кодыг ашиглан мэдээллийн санд мэдээллийг оруулна.

2.3. Мэдээллийн санг бүрдүүлэх, нууцлалыг хадгалах, аюулгүй байдлыг хангах асуудлыг Онцгой байдлын ерөнхий газарт Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, нийслэл, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад эрүүл мэндийн асуудал хариуцсан алба хаагч хариуцна.

2.4. Онцгой байдлын байгууллага нь Хувь хүний нууцын тухай хууль болон Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу алба хаагчдын эрүүл мэндийн цаасан болон цахим мэдээллийн нууцлалыг хадгална.

2.5. Алба хаагчдын эрүүл мэндийн мэдээллийг шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагатай цахимаар солилцож, мэдээллийн санг баяжуулна

Гурав. Мэдээллийн системийг ашиглах талуудын эрх, үүрэг

3.1. Онцгой байдлын ерөнхий газрын эрүүл мэндийн асуудал хариуцсан нэгж нь мэдээллийн санг ашиглах асуудлаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Дараах эрхтэй.

3.1.1.1. Мэдээллийн санд эрх бүхий албан тушаалтан нэвтрэх код ашиглан алба хаагчдын мэдээлэлтэй танилцах,

3.1.1.2. Цахим бүртгэл, мэдээллийн системийн хөгжүүлэлтийг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох нэгжид санал гаргах,

3.1.2. Дараах үүрэгтэй.

3.1.2.1 Мэдээллийн санд үндэслэн алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх,

3.1.2.2 Алба хаагчдад чиглэсэн сэтгэл зүйн сорил, судалгаа, зөвлөгөө, зөвлөмжийн материалыг тухай бүр мэдээллийн санд байршуулах,

3.1.2.3 Алба хаагчдын эрүүл мэндийн талаарх мэдээллийг холбогдох эрүүл мэндийн байгууллагатай солилцох, аюулгүй байдлыг хангаж, нууцлалыг хадгалах.

3.2. Нийслэл, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын эрүүл мэндийн асуудал хариуцсан алба хаагч нь мэдээллийн санг ашиглах асуудлаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.1. Дараах эрхтэй.

3.2.1.1. Мэдээллийн санд нэвтрэх кодоор хандаж алба хаагчдын эрүүл мэндийн мэдээллийг бүртгэх, баяжуулах.

3.2.2. Дараах үүрэгтэй.

3.2.2.1. Онцгой байдлын ерөнхий газрын Эрүүл мэндийн асуудал хариуцсан нэгжид алба хаагчдын эрүүл мэндтэй холбоотой тайлан мэдээг тухай бүр гаргаж ирүүлэх,

3.2.2.2. Алба хаагчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, өвчлөлийн харьцуулсан судалгааг хийх,

3.2.2.3. Алба хаагчдын эрүүл мэндийн байдалд дүгнэлт хийж, шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмчийн хяналтад хамруулах,

3.2.2.4. Мэдээллийн санд суурилан алба хаагчдыг товлот дархлаажуулалтад тогтмол хамруулах,

3.2.2.5. Эрүүл мэндийн байгууллага болон Онцгой байдлын ерөнхий газраас гаргасан журам, заавар, зөвлөгөө, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгох,

3.2.2.6. Алба хаагчдын эрүүл мэндийн талаарх мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, нууцлалыг хадгалах.

Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Гамшгийн шуурхай удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан нэгж, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар хяналт тавьж ажиллана.

4.2. Энэхүү журмыг зөрчсөн алба хаагчдад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--